

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР
ДАРГА Б.ЛХАГВА ТАНАА

2020 02.27 № 06/625
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Б.Лхагва Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн зарцуулалт, тайлагнал, цалинтай чөлөө олгохдоо Төсвийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг баримталж байх, ашиглалтгүй үндсэн хөрөнгийг данснаас хасах, харилцагч байгууллагуудад өглөг үүсгэхгүй байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 10-наас 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Аккурэйт финанс Аудит ХХК-ийн баг хариуцаж хэрэгжүүлэв.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/90 дугаар бүхий албан бичгээр Үндэсний Аудитын газарт ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Зах зээлд шударга өрсөлдөөний таатай орчин бүрдүүлэх, хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлж, улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог төлөвшүүлэхэд оршино.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих.
- Өрсөлдөөнд оролцож, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн үйл ажиллагааг шалгаж дүгнэлт гаргах.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Төсвийн тухай хууль
Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
Шилэн дансны тухай хууль
Өрсөлдөөний тухай хууль
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль
Нийгмийн Даатгалын тухай хууль
Хөдөлмөрийн тухай хууль
Төрийн сангийн үйл ажиллагааны журам
Төсвийн байгууллагын мөнгөн кассын журам

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoulous 3.0” программ хангамж ашигладаг байна.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 464,829.1 мянган төгрөгөөс тооцон 4,648.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 9,164.3 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал төлөвлөлтийн үе шатанд тооцсон дүнгээс 451,605.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,243.5 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансуудтай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,307.6	589.9	-717.7
Урьдчилгаа			
Бараа материал	50,168.1	56,851.1	6,683.0
Үндсэн хөрөнгө	31,037.7	21,828.9	-9,208.8
Нийт хөрөнгө	82,513.4	79,269.9	-3,243.5
Өр төлбөр	-	14,254.7	14,254.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	164,450.9	164,450.9	-
Хуримтлагдсан үр дүн	-85,278.4	-102,776.6	-17,498.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,340.9	3,340.9	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	82,513.4	79,269.9	-3,243.5

Авлага дансны үлдэгдэл буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 1,307.6 мянган төгрөгийг тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлд суутган тооцуулсан байна. Хаан банкны системийн алдаанаас шалтгаалан 2 гүйлгээ буцсанаас 589.9 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 87,386.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 80,703.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацаанд 1,239.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан бөгөөд нийт 10,448.4 мянган төгрөг элэгдэл байгуулан хуримтлагдсан элэгдэл 366,583.4 мянган төгрөг болон өссөн нь шалтгаалжээ.

Биет бус хөрөнгө программ хангамж хасагдуулгын дүнгээр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь Төрийн албаны тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 24 дүгээр тогтоол, УИХ-ын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21 дүгээр тогтоол, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоолын дагуу цалингийн шатлал, зэрэг дэв нэмэгдсэнтэй холбоотой цалингийн сан хүрэлцэхгүй НДШ-ийн 13,534.7 мянган төгрөг, ХХОАТ-ын 130.0 мянган төгрөг өглөг үүссэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар тайлант онд 38,707.2 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй орлогыг бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 898,346.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь тайлант онд 896,839.9 мянган төгрөгийн төсөв зарцуулж 99.8 хувийн гүйцэтгэлтэй гарч 1,506.3 мянган төгрөг хэмнэсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 9 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 54,964.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад ажилтан албан хаагчдын томилолтын зардлын тооцоог гүйцээж, мөшгин шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 124 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2015 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын 2.2-т заасан шаардлагыг хангасан тул Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын 10.7.2-т заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн

гүйцэтгэлд аудит хийлгүй Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/156 дугаар тушаалаар итгэл үзүүлж итгэмжлэл олгосон байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөд түүврээр тооллого хийхэд 24,650.0 мянган төгрөгийн өртөг бүхий гадна гэрэлтдэг хаяг, 11,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий насос биетээр оршин байгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-дүгээр заалт зөрчигдөж байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, хөрөнгийн элэгдэл үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасахад холбогдох байгууллагын шийдвэр авна” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид энэ зөрчлийг давтахгүй байхаар анхаарч ажиллана.

2. Өглөгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

НДШ-ийн 13,534.7 мянган төгрөг, ХХОАТ-ын 130.0 мянган төгрөгийн өглөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 хэсэг дэх “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Хууль тогтоомж хэрэгжихгүй байх, өр төлбөр үүсэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, ХХОАТ-ын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, өр төлбөр үүсгэхгүй байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид энэ зөрчлийг давтахгүй байхаар анхаарч ажиллана.

3. Цалингийн зардалтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Байгууллагын даргын тушаалаар 2019 онд нэр бүхий 9 хүнд цалинтай чөлөө өгч 4,745.5 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасан “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн тухай хуулийн заалт, бусад холбогдох журам зөрчигдөх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтууд болон “Хөдөлмөрийн дотоод журам”-ын заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг дахин давтахгүй байх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид энэ зөрчлийг давтахгүй байхаар анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>51,475,705.80</u>	<u>57,441,014.60</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	--
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	1,307,587.88	589,936.00
33100	Ажиллагсадтай холбоотой авлага	1,307,587.88	-
3351	Байгууллагаас авах авлага	-	589,936.00
35	БАРАА МАТЕРИАЛ	50,168,117.92	56,851,078.60
354	Хангамжийн материал	50,168,117.92	56,851,078.60
35410	Бичиг хэргийн материал	12,405,402.00	22,640,716.00
35420	Аж ахуйн материал	3,402,227.00	3,757,461.00
35440	Түлш, шатах тослох материал	160,003.92	334,011.60
35470	Бусад хангамжийн материал	34,200,486.00	30,118,890.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,037,665.60</u>	<u>21,828,897.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	31,037,665.60	21,828,897.90
392	Биет хөрөнгө	23,430,797.80	19,713,067.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	86,215,000.00	86,215,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-86,215,000.00	-86,215,000.00
39205	Тоног төхөөрөмж (компьютер)	151,501,300.00	151,931,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-143,342,466.26	-144,445,178.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,346,439.12	47,156,239.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,074,475.06	-34,929,192.28
393	Биет бус хөрөнгө	7,606,867.80	2,115,829.96
39301	Программ хангамж	65,188,490.00	65,188,490.00
39302	Хасагдуулга	-64,956,830.00	-65,072,660.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,092,500.00	16,092,500.00
39304	Хасагдуулга	-8,717,292.20	-14,092,500.04
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>82,513,371.40</u>	<u>79,269,912.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	14,254,743.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	14,254,743.66
413	Өглөг	-	14,254,743.66
4131	Ажиллагсадтай холбоотой өглөг	-	13,664,807.66
4136	Бусад өглөг	-	589,936.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	300,000.00
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	-	289,936.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>82,513,371.40</u>	<u>65,015,168.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	82,513,371.40	65,015,168.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,450,991.00	164,450,991.00
51101	Өмч: - төрийн	164,450,991.00	164,450,991.00

512	Хуримтлагдсан үр дүн	-85,278,494.07	-102,776,696.63
51210	Өмнөх үеийн үр дүн	-85,278,494.07	-85,278,494.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	-17,498,202.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,340,874.47	3,340,874.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>82,513,371.40</u>	<u>79,269,912.50</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	951,849,000.00	898,936,236.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	589,936.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	589,936.00
120020	Төсөв байгууллагын орлого	-	589,936.00
1200045	Бусад орлого	-	589,936.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	951,849,000.00	898,346,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	951,849,000.00	898,346,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951,849,000.00	898,346,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	960,136,861.41	916,434,438.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	951,849,000.00	898,346,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	886,113,081.34	847,552,532.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	450,111,472.36	548,567,919.16
210101	Үндсэн цалин	333,694,194.36	475,427,315.16
210102	Нэмэгдэл цалин	64,215,400.00	46,680,604.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,201,878.00	26,460,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,535,904.28	71,739,660.38
210201	Тэтгэврийн даатгал	39,283,676.28	53,165,291.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,948,095.00	4,643,742.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,816,296.00	2,489,348.46
210204	Ажилгүйдлийн даатгал	2,590,587.00	4,605,684.60
210205	Эрүүл мэндийн даатгал	9,897,250.00	6,835,593.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,540,220.00	1,590,400.00
210301	Гэрэл цахилгааны зардал	67,000.00	215,400.00
210304	Байрны түрээс	43,473,220.00	1,375,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	113,271,101.49	93,556,843.32
210401	Бичиг хэрэг	32,439,928.00	21,155,899.00
210402	Тээвэр, шатахуун	15,393,986.08	17,393,691.32
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,029,092.41	16,669,606.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,408,095.00	38,337,647.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,407,753.00	6,403,100.00
210601	Багаж хэрэгсэл	7,370,630.00	3,236,200.00
210604	Урсгал засвар	3,037,123.00	3,166,900.00
210701	Томилолт, зочины зардал	3,828,602.00	6,132,700.00
210702	Дотоод томилолтын зардал	1,518,000.00	5,884,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	2,310,602.00	248,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,408,365.00	83,748,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,204,828.00	61,594,120.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,000,000.00

210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	18,184,050.00	19,739,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,300.00	210,300.00
210805	Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	72,000.00	166,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	7,344,187.00	605,000.00
210807	Газрын төлбөр	393,000.00	433,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,009,663.21	35,813,029.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,982,375.00	25,364,562.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,027,288.21	10,448,467.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,023,780.07	68,881,906.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,785,380.96	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	2,785,380.96	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,410,869.00	67,375,543.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,410,869.00	35,810,691.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,564,852.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,827,530.11	1,506,363.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,827,530.11	1,506,363.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,287,861.41	-17,498,202.56
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,181,932.76	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	23,181,932.76	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-23,818,932.76	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-31,469,794.17	-17,498,202.56

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>951,849,000.00</u>	<u>898,936,236.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	951,849,000.00	898,936,236.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	951,849,000.00	898,936,236.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951,849,000.00	898,936,236.00
1400	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	589,936.00
140020	Бусад орлого/	-	589,936.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>947,849,000.00</u>	<u>898,936,236.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,849,000.00	898,936,236.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	873,448,779.41	825,645,546.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	452,793,300.00	540,663,200.00
210101	Үндсэн цалин	335,434,300.	390,677,313.00
210102	Нэмэгдэл	64,439,000.00	97,065,887.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,920,000.00	52,920,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,372,800.00	65,020,300.00
210201	Тэтгэврийн даатгал	36,261,000.00	44,213,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,527,900.00	5,201,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,387,100.00	4,161,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,140,900.00	1,040,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,055,900.00	10,403,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,736,612.00	10,435,820.00
210301	Гэрэл цахилгааны зардал	205,750.00	215,400.00
210304	Байрны түрээс	17,530,862.00	10,220,420.00
2104	Хангамж, бараа материалын зардал	44,868,599.41	50,208,300.00
210401	Бичиг хэрэг	11,914,931.41	16,917,600.00
210402	Тээвэр, шатахуун	13,110,800.00	13,110,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,478,200.00	17,478,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,364,668.00	2,701,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,107,031.00	16,140,400.00
210601	Багаж техник хэрэгсэл	6,731,603.00	5,732,000.00
210604	Урсгал засвар	22,375,428.00	10,408,400.00
2107	Томилолт, зочины зардал	6,514,145.00	15,680,100.00
210702	Дотоод томилолтын зардал	1,518,000.00	7,680,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	4,996,145.00	8,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	221,431,777.00	92,777,664.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	189,454,760.00	63,715,604.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	18,184,050.00	18,199,760.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,300.00	210,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	72,000.00	100,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	13,117,667.00	9,118,300.00
210807	Газрын төлбөр	393,000.00	433,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,624,515.00	34,719,762.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,624,515.00	34,719,762.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,400,220.59	73,290,690.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,422,690.48	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,422,690.48	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,150,000.00	71,194,391.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	42,150,000.00	37,966,323.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	31,564,852.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,663,216.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,827,530.11	2,096,299.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,827,530.11	2,096,299.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,000,000.00	=
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,000,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,000,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	4,000,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,000,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,000,000.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	250,489,989.07	418,281,854.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	250,489,989.07	418,281,854.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
C07	Тайлант үеийн үр дүн			-115,653,148.25	-115,653,148.25
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	-85,278,494.07	82,513,371.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	-85,278,494.07	82,513,371.40
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн			-17,498,202.56	-17,498,202.56
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	-102,776,696.63	65,015,168.84

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	898,346,300.00	896,839,937.00	1,506,363.00	99.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,346,300.00	896,839,937.00	1,506,363.00	99.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	826,346,300.00	826,346,300.00	700,754.00	99.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	540,663,200.00	540,663,200.00	-	100.0
210101	Үндсэн цалин	390,435,700.00	390,435,700.00	-	100.0
210102	Нэмэгдэл	97,307,500.00	97,307,500.00	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,920,000.00	52,920,000.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,020,300.00	65,020,300.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	44,213,900.00	44,213,900.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,201,600.00	5,201,600.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,161,200.00	4,161,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,040,300.00	1,040,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10,403,300.00	10,403,300.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,462,000.00	10,435,820.00	26,180.00	99.75
210301	Гэрэл цахилгааны зардал	221,400.00	215,400.00	6,000.00	97.29
210304	Байрны түрээс	10,240,600.00	10,220,420	20,180.00	99.80
2104	Хангамж, бараа материалын зардал	50,280,300.00	50,280,300.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	16,917,600.00	16,917,600.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	13,110,800.00	13,110,800.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,478,200.00	17,478,200.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,701,700.00	2,701,700.00	-	100.0
2106	Эд хогшил, худалдан авах	16,140,400.00	16,140,400.00	-	100.0
210601	Багаж техник хэрэгсэл	5,732,000.00	5,732,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,408,400.00	10,408,400.00	-	100.0
2107	Томилолт, зочины зардал	15,680,100.00	15,680,100.00	-	100.0
210702	Дотоод томилолтын зардал	7,680,100.00	7,680,100.00	-	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,433,100.00	92,777,664.00	655,436.00	99.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,278,700.00	63,715,604.00	563,096.00	99.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	18,292,100.00	18,199,760.00	92,340.00	99.50
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,300.00	210,300.00	-	100.0

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	100,000.00	-	100.0
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	9,118,300.00	9,118,300.00	-	100.0
210807	Газрын төлбөр	433,700.00	433,700.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,738,900.00	34,719,762.00	19,138.00	99,94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,738,900.00	34,719,762.00	19,138.00	99,94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,000,000.00	71,194,391.00	805,609.00	98,88
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,000,000.00	71,194,391.00	805,609.00	98,88
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,200,000	37,966,323.00	233,677.00	99,39
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,000,000.00	31,564,852.00	435,148.00	98.64
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	1,663,216.00	136,784.00	92.40
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	898,346,300.00	898,346,300.00	-	100.0
1320	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	898,346,300.00	898,346,300.00	-	100.0
132001	Улсын төсвөөс санхүүжих	898,346,300.00	898,346,300.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36	36		100.0
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1		100.0
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	35	35		100.0

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	<i>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан</i>	Аудитын код:
2020.02.21			САГ-2020/7/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<i>Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар</i>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуулл агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаал	
				Нэр	Албан тушаал
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгөд түүврээр тооллого хийхэд 24,650.0 мянган төгрөгийн өртөг бүхий гадна гэрэлтдэг хаяг, 11,900.0 мянган төгрөгийн өртөг бүхий насос биетээр оршин байгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-дүгээр заалт зөрчигдөж байна.	36,550.0	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Б.Лхагва Д.Одгэрэл
2	Байгууллагын даргын тушаалаар 2019 онд нэр бүхий 9 хүнд цалинтай чөлөө өгч 4,745.5 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасан “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй нийцэхгүй байна.	4,745.5	зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Б.Лхагва Д.Одгэрэл
3	НДШ-ийн 13,534.7 мянган төгрөг, ХХОАТ-ын 130.0 мянган төгрөгийн өглөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 хэсэг дэх “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.	13,664.7	зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	Б.Лхагва Д.Одгэрэл
	Дүн	54,960.2			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines providing space for writing the conclusion.